

**ЭЛЧИН ЗӨВЛӨХ, ДОКТОР Ц. БАТБАЯР:
ХКН-ЫН ХҮШ ИХ ХУРЛААС 2020 ОН ГЭХЭД
ДУНДАЖ ЧИНЭЭЛЭГ НИЙГЭМ БАЙГУУЛАХ
ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЛЭЭ**

Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны
Элчин зөвлөх, доктор Цэдэндамбын Батбаяртай
ХКН-ын ХҮШ их хурлын үр дүнгийн
талаар хийсэн сонирхолтой ярилцлагыг
уншигчиддаа толилуулж байна.

Олон улс судлал сэтгүүлийн редакци

Д. Шүрхүү: *Юуны өмнө манай хүсэлтийг хүлээн авч ярилцлага өгч буйд талархал илэрхийлье. 2012 оны 11-р сард өмнөд хөрш БНХАУ-д эрх баригч ХКН-ын ХҮШ их хурал болж өнгөрлөө. Таван жилд нэг удаа болдог энэ их хурлын онцлог юу байв?*

Ц. Батбаяр: Үнэхээр 5 жилд нэг удаа болдог энэ удаагийн их хурлаар БНХАУ-ын хөгжлийн ирэх 10 жилийн өнгө аясыг тодорхойлсноос гадна ирэх 10 жилд 1 тэрбум гаруй хүн амтай энэ том гүрнийг удирдах нам, төрийн дээд удирдлагыг сонгож тодруулсан нь онцлог үйл явдал боллоо. Дэн Сяопин 1978 онд Хятадын өөрчлөлт шинэчлэлтийг эхлүүлснээс хойших 30 гаруй жилийн хугацаанд олсон ололт амжилтыг нэгтгэн дүгнэж, ирэх 10 жил, цаашилбал ирэх 40 жилийн Хятадын хөгжлийн үзэл баримтлалыг баталлаа. Дэн Сяопины дэвшүүлсэн “Хятад улс социализмын анхан шатандаа яваа бөгөөд энэхүү шат нь 100 жил ч үргэлжилж болно” гэсэн онолыг бататгаж, ХКН-аас БНХАУ байгуулагдсаны 100 жилийн ой буюу 2049 он гэхэд чинээлэг, хүчирхэг, ардчилсан соёл иргэншил бүхий социалист улс болох зорилтыг дэвшүүлэв. Олон улс болон дотоодын байдлаас харахад Хятад улс хөгжил цэцэглэлийн стратегийн тааламжтай цаг үедээ байгааг Хятадын удирдагчид онцолж энэхүү стратегийн боломж, нөхцлийг цаг алдалгүй бүх талаар ашиглан 2020 он гэхэд дундаж чинээлэг нийгэм (moderately prosperous society) байгуулах зорилтоо биелүүлэхийн төлөө ажиллахыг уриалсан.

Д. Шүрхүү: *Хятад улс өнгөрсөн жил Японыг гүйцэн түрүүлж эдийн засгийн үнэмлэхүй хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт орох*

эдийн засаг болж хувирсан. Гэвч Европын санхүүгийн хямрал зэргээс шалтгаалан эдийн засгийн хурдац буурч байгаа явдал ажиглагдаж эхэллээ.

Ц. Батбаяр: Тийм ээ. Хятадын эдийн засаг өнгөрсөн 30 жилд, ялангуяа сүүлийн 15 жилд жилд дунджаар 12-15 хувиар өсөж, 2011 оны байдлаар 7.3 их наяд/триллион/ ам. доллартай тэнцэх ДНБ-тэй болж, дэлхийд АНУ-ын дараа хоёрдугаарт бичигдэх болсон юм. Хот, хөдөөгийн хүн амын орлого ч түргэн өсөж, нэг хүнд ноогдох орлого нь 2011 оны байдлаар 4000 ам. долларт хүрч дундаж орлоготой орнуудын эгнээнд багтах боллоо. Эдийн засгийн асар их хурдтай хөгжлийг дагалдан байгаль орчин, хүрээлэн буй орчны доройтол, хот хөдөөгийн ялгаа, хүн амын орлогын зөрүү, нийгмийн халамжийн асуудлууд хуримтлагдан гарч ирснийг ХКН-ын их хурлын тайлан илтгэлд ил тодоор хүлээн зөвшөөрлөө. Энэ жил Хятадын эдийн засаг 7.5 хувь өсөх төлөвтэй байгаа бөгөөд ирэх 5 жилд 7 хувиас бууруулалгүй барих зорилт тавьж байна. Дэлхийн банкнаас ноднин боловсруулсан “Хятад улс 2030 онд” гэсэн илтгэлээс үзэх юм бол БНХАУ-ын ДНБ-ний жилийн дундаж өсөлт 2011-15 онд 8.6 % байх бол, 2016-2020 онд 7%, 2021-25 онд 5.9%, 2026-2030 онд 5% болж буурах хандлага ажиглагдаж байна.

Д. Шүрхүү: *ХКН-ын ХҮШ их хурлаас Хятадын өнөөгийн эдийн засгийн хэлбэр, загварыг өөрчлөх талаар их яригдлаа. Энэ чухам ямар өөрчлөлтийг хэлж байна вэ?*

Ц. Батбаяр: Их хурлын тайлан илтгэлд өнөөгийн зах зээлийн эдийн засгийн бүтэц, хөгжлийн хэв загварын (growth model) өөрчлөлтийг шуурхайлах, шинжлэх ухаанчаар хөгжихийг уриалж, эдийн засгийн хөгжлийн шинэ хэлбэрийг бий болгох хэрэгтэйг онцлон заав. Хятадын онцлогтой орчин үеийн аж үйлдвэр, мэдээлэлжүүлэлт, хотжилт, ХАА-н өөрчлөлт шинэчлэлтийг хийх, энэ хүрээнд дээрх 4 салбарын өөрчлөлт шинэчлэлтийг зэрэг хэрэгжүүлэх, мэдээлэлжүүлэлт ба аж үйлдвэржилт, аж үйлдвэржилт ба хотжилт, хотжилт ба ХАА-н өөрчлөлт шинэчлэлтийг нарийн нягт уялдаа холбоотой явуулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна. Өмнөх хөгжлийн загвар нь Хятадын хямд ажиллах хүчинд тулгуурласан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, дэлхийн зах зээлд экспортлох, экспортоос олсон орлогоор баялагийг бүтээх хөгжлийн загвар байсан. Гэвч АНУ-ын санхүүгийн хямрал, Европын өрийн хямрал зэрэг гадаад хүчин зүйлээс шалтгаалан Хятадын экспортын зах зээл хумигдсанаас цаашид энэхүү экспортонд түшиглэсэн хөгжлийн

загвар явцгүй болсныг бүгд ярьж байна. Иймд цаашид өөрийн асар том дотоод зах зээлдээ түшиглэн дотоод эрэлт хэрэгцээгээ нэмэгдүүлэх, техникийн инновацийг чухалчлан, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх шинэ хөгжлийн загварт шилжих нь зүйтэй гэсэн зүйлийг Их хурлаар ярьж баталгаажууллаа.

Д. Шүрхүү: *Та сая хотжилтын асуудлыг хөндлөө. Хятад улс цаашидаа хэр хотжих вэ?*

Ц. Батбаяр: Хятадын хүн амын хотжилт түргэн хурдацтай нэмэгдэж 2011 он гэхэд хотын хүн ам 51.3 хувьд хүрч анх удаа хотын хүн ам хөдөөгийн хүн амаас давж гарлаа. Гэвч 50 хувийн хотжилтыг бага байна гэж тооцож байна. Дэлхийн хөгжилтэй орнуудад хотжилтын хувь 70-80 орчим, хөгжиж буй орнуудад 60 орчим хувь байдаг байна. Бразилд гэхэд хүн амын 80% нь хотод амьдардаг ажээ. Хятадын эдийн засагчдын тооцоогоор ирэх 20 жилд шинээр 350-400 сая хүнийг хотжуулах зорилт тулгарч байгаа ажээ. Хотжилтыг дагалдаад хотуудын дэд бүтцийг бий болгох, ялангуяа Хятадын төв болон баруун хэсэгт шинэ хотуудыг бүтээн байгуулах, хотын хүн амын улам бүр өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг хангах асуудал гарч ирнэ гэж үзэж байна.

Д. Шүрхүү: *2020 он гэхэд дундаж чинээлэг нийгмийг байгуулна гэсэн зорилт дэвшүүлжээ. Энэ зорилтыг яаж хангах вэ?*

Ц. Батбаяр: Хөгжлийн тэнцвэртэй болон тогтвортой байдлыг хангаж, хөгжлийн загварыг өөрчлөх ажлыг түргэтгэх, 2020 он гэхэд нийт ДНБ-ийг болон хот, хөдөөгийн оршин суугчдын нэг хүнд ногдох орлогыг 2010 оныхтой харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэв. БНХАУ-ын 2010 оны ДНБ /39.8 их наяд юань/ болон хот, хөдөөгийн хүн амд ноогдох орлого /19109 юань болон 5919 юань/ -ыг тус тус 2020 он гэхэд хоёр дахин нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ирэх 9 жилд ДНБ-ийг жилд дунджаар 7 хувьтай, нэг хүнд ноогдох орлогыг жилд дунджаар 6.8 хувьтай өсгөхөд хэрэгжүүлэх боломжтой гэж Хятадын удирдлага үзэж байна. Ингэснээр 2020 он гэхэд хотын хүн амд ноогдох дундаж орлого 38 000 орчим юань, хөдөөгийн хүн амд ноогдох дундаж орлого 12 000 орчим юань болох дүр зураг харагдаж байна. Гэвч үүний зэрэгцээ бүс нутгийн болон хүн амын орлогын зөрүүг тэнцвэржүүлэх, орон нутгийн засгийн газрын асар их өрийн асуудлыг шийдэх, хотын орон сууц, үл хөдлөх хөрөнгөний үнийн хөөрөгдлийг намжаах зэрэг тулгамдсан олон асуудлууд

байгааг гаднын шинжээчид тэмдэглэж байна.

Д. Шүрхүү: Барууны эдийн засагчид “middle income trap” буюу дунд орлоготой орнууд тэр болгон хүн амынхаа орлогыг өндөр орлоготой шатанд дэвшүүлж чаддаггүй, янз бүрийн шалтгаанаас болоод “дундаж орлогын занга”-нд орж нэг түвшинд гацах, бүр хойшоо ухрах ч зүй тогтол байдгийг их бичдэг. Хятадын хувьд энэхүү дундаж нэг хунд ноогдох орлого 4000 орчим ам. доллар хүрсэн шатнаас өндөр орлоготой шатанд дэвших явц ямархуу сорилтуудтай тулгарч болох вэ?

Ц. Батбаяр: Түрүүн миний дурьдсан Дэлхийн банкны илтгэлд энэхүү “middle income trap” буюу дундаж орлоготой орнуудын нийтлэг бэрхшээл сорилтуудын тухай, ялангуяа Хятадын хувьд юуг анхаарвал зохилтой тухай дүн шинжилгээ хийжээ. Дэлхийн II дайны дараа нэлээд олон орнууд түргэн хугацаанд дундаж орлоготой болж чадсан боловч тэднээс тун цөөхөн нь өндөр орлоготой орнуудын эгнээнд дэвшиж чаджээ. Өөрөөр хэлбэл, тэдний ихэнх нь ялангуяа Аргентин, Бразиль, Чили, Колумб, Мексик зэрэг Латин Америкийн орнууд “дундаж орлогын занга”-нд орж, тэндээс сугарч гарч чадаагүй байна. Түргэн хөгжиж дундаж орлоготой болсон орнуудын нийтлэг шинж бол хямд өртөгтэй хөдөлмөрлөх хүч болон гаднын бэлэн технологийг тэр чигээр нь нэвтрүүлэн ашигласан энэ хоёр хүчин зүйлийг хослуулж чадсанаар хэрэгжүүлсэн байдаг. Дэлхийн дайнаас хойш түргэн хөгжлийг 25 жил буюу түүнээс илүү хугацаанд хадгалж чадсан нийт 13 эдийн засаг байна. Үүнд Япон, Өмнөд Солонгос, Бразиль, Ботсвана, Индонез, Малайз, Сингапур, Тайван зэрэг эдийн засаг багтдаг байна. Гэвч түргэн хөгжлийн тодорхой шатыг өнгөрсний дараа хөгжлийн өмнөх хүчин зүйлүүд ажжмаар үйлчлэхгүй болж, хөгжлийн шинэ хөдөлгүүр хүчийг хайх хэрэгтэй болдог. Хямд ажиллах хүчний нөөц шавхагдаж, хөдөлмөр их шингэсэн боловсруулах үйлдвэрүүд ашиггүй болж технологийн дараачийн шатанд шилжих хэрэгцээ бий болдог. Үүнтэй уялдан мэргэжлийн өндөр ур чадвартай ажилчдын хэрэгцээ нэмэгдэж, тэдний төлөө өрсөлдөөн ширүүсэж, ур чадвар, нэмүү өртөг, оюун ухаан шингэсэн салбаруудыг хөгжүүлэхгүй бол дараачийн хөгжлийн эрэмбэд дэвшиж чадахгүйд хүрдэг гашуун туршлага олон бий. Түрүүн дурдсан түргэн хөгжлийг 20 гаруй жил хадгалж чадсан 13 эдийн засгаас дөнгөж 6 эдийн засаг л өндөр орлоготой эдийн засгийн эгнээнд амжилттай дэвшин орж чадсан байна. Үүнд Япон, Сингапур, Мальт, Тайван, Хонконг, Өмнөд Солонгос багтдаг

байна. Эдгээр эдийн засаг хөдөлмөр шингэсэн салбаруудаа оюун ухаан, хөрөнгө шингэсэн салбарууд болгож хөгжүүлэх технологийн дэвшлийг урьдчилан төлөвлөж, цаг тухайд нь хийж чадсанд тэдний амжилтын нууц оршино гэж үздэг байна.

Д. Шүрхүү: *Хятадад хээл хахууль, авилгатай хийх тэмцлийг чангатгахаар Их хурлаас шийдсэн гэсэн. Энэ талаар тайлбарлахгүй юу?*

Ц. Батбаяр: ХКН-ын их хурлаас намыг авлигаас ангид байлгах, авилгын эсрэг тэмцлийг онцгой анхаарч, хуулийн өмнө хэн ч бай, ямар ч өндөр албан тушаалтай байхаас үл хамааран авилга авсан бол шийдвэртэйгээр шалган шийдвэрлэж, хатуу тэмцэнэ гэдгээ мэдэгдэв. Чунцин хотын намын хороон дарга Бо Сылай, Төмөр замын яамны сайд Лю Жызюнь зэрэг хүмүүсийн асуудлыг шалгаж шийдвэрлэсэн нь ХКН авилгаас ангид байх, авилгатай тэмцэх шийдвэр төгс байгааг илтгэн харууллаа гэж сурталчилж байна. ХКН-ын 18-р их хурал авилгын эсрэг ажлыг маш их чухалчлан үзсэн бөгөөд улс орон, эрх баригч намын цаашдын хувь заяа ч авилга, хээль хахуультай хэрхэн тэмцэхээс хамаарна гэж их хурлын индрээс зарласан. ХКН-ын Сахилга батын хороо ч мөн авлигаас урьдчилан сэргийлэх 2013-2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан бөгөөд намын дотор авлигын эсрэг сургалт, урьдчилан сэргийлэх, хянах, таслан шийдвэрлэх ажлын тогтолцоог улам бүр сайжруулна гэжээ.

Д. Шүрхүү: *ХКН-ын их хурлаас намын удирдах дээд байгууллагыг бурдуулсан. Ямар хүмүүс ирэх 10 жилд Хятадыг удирдах вэ?*

Ц. Батбаяр: Энэ удаагийн Их хурал дэлхийн олон нийтийн анхаарлын төвд байсан бас нэг гол шалтгаан бол дэлхийн хамгийн их хүн амтай, хоёр дахь том эдийн засагтай Хятад улсыг ирэх 10 жилд удирдах ХКН-ын 5 дахь үеийн удирдлагыг сонгосон явдал байлаа. Хятадын 5 дахь үеийн удирдагчид болох Си Жиньпин тэргүүтэй ХКН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны Байнгын хорооны 7 гишүүн болон УТТ-ний 25 гишүүний хувьд зарим нийтлэг шинжүүд ажиглагдаж байна. Эдгээр хүмүүсийн дийлэнх нь Хятадын өөрчлөлт шинэчлэлтийн үед өсч, хүмүүжсэн учир коммунист ёс суртахуунаас илүү прагматик үзэл бодолтойгоороо адилхан. Тэдгээрийн боловсролын хувьд өмнөх үеийн инженерийн мэргэжилтнүүдээс голчлон бүрдсэн технократууд бус харин хууль эрх зүйч, эдийн засагч, түүхч зэрэг нийгэм, хүмүүнлэгийн ухаан голлосон янз

Ярилцлага

бүрийн мэргэжлийн хүмүүсийн төлөөлөл орсон тул хятадын төрийн бодлогын шийдвэр илүү олон талт, прагматик болох зэрэг нөхцөл үүсэж болох юм гэж гадны ажиглагчид үзэж байна.

Д. Шүрхүү: ХКН-ын ХҮШ их хурлын намын ур дунгийн талаар сонирхолтой ярилцлага өгсөн танд дахин талархал илэрхийлэхийн хамт өндөр нэр хүнд, харицлагатай дипломатийн алба болон эрдэм номын ажилд их амжилт хусье.